

БАТЛАВ БПК-ийн ЗАХИРАЛ
Г.НЯМДУЛАМ



**“ЦАХИМ ХИЧЭЭЛ – 2020”
уралдааны удирдамж**

ЗОРИЛГО

Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалтанд шинэ мэдээллийн технологийг нэвтрүүлэх зорилгоор мультимедиа, цахим сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалтыг сайжруулах, цахим орчинд ажиллах багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, туршлага хуваалцах, шилдэг цахим хичээлийг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ

Барилгын политехник коллежийн бүх багш нар

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Сургалт арга зүйн зөвлөл

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Уралдаанд оролцох багш нар шилдэг цахим хичээлээ 2020 оны 01-р сарын 06-ны дотор CA33-д CD/DVD дээр буулган 201 тоот сургалтын арга зүйч Н.Саранхүүд өгнө.

ЦАХИМ ХИЧЭЭЛД ТАВИГДАХ ШАЛГУУР

Нийтлэг шаардлага:

- Хичээлийн агуулгын хүрээнд тодорхой нэг хэсгийг сонгон авч хийнэ.
- Бэлтгэсэн хичээл нь биеэ даасан аппликэйшн байхаас гадна интернэт хөтөч ашиглан тоглуулах боломжтой байх
- Сургалтын агуулгын хүрээнд багтсан, суралцагчдын нас сэтгэхүйн онцлогийг харгалзсан байх

Хичээл нь:

- ✓ Сургалтын дидактик зарчмыг баримтлах, цахим хичээлийн боловсруулалт бүрэн хийгдсэн, чанартай байх
- ✓ Сургалтын стандарт хангасан дизайнтай байх
- ✓ Үр дүнг тооцох сорилтой байх
- ✓ Стандарт шаардлага хангасан дуу, хоолойн бичлэг, видео /HD/ агуулсан байх
- ✓ Хөдөлгөөнт болон фото /300 pixel/ зураг агуулсан байх
- ✓ Дэлгэцэнд 8-15 мөр тэмдэгтээс ихгүй, агуулга нь товч тодорхой, хоёрдмол утга агуулаагүй байх
- ✓ Удирдлагын товчлууртай /button/ байх
- ✓ Ном сурах бичиг, материалтай байх /pdf, swf tool, flipdoo/
- ✓ Мэргэжлийн үг хэллэгийн тайлбар толь бичигтэй байх
- ✓ Тухайн цахим хичээлийг цахим сайтад байршуулж, нийтэд хүртээмжтэй ашиглах боломжтой байхаар бэлтгэгдсэн байна.

Нэмэлт шалгуур:

- 2D/3D график
- Сурах идэвхийг сэдэлжүүлэх тоглоом
- Мэргэжлийн програм ашиглаж болно /articulate, captivate/

ШАЛГАРУУЛАЛТ

Шалгаруулалт 2020 оны 01-р сарын 08-ны өдрийн 10.00 цагт лекцийн танхимд болно. Шалгаруулалтанд орох цахим хичээлийн танилуулгыг нийт багш нарт нээлттэй үзүүлж түгээн дэлгэрүүлнэ.

Дүгнэх хэлбэр:

1. Урьдчилсан үнэлгээ /16 хүртэл оноо/ Шүүгчид
2. Хамгаалалт /4 хүртэл оноо/ Оролцогч

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- | | |
|--------------|--------------------------|
| I байр – 1 | ӨРГӨМЖЛӨЛ, мөнгөн шагнал |
| II байр – 1 | ӨРГӨМЖЛӨЛ, мөнгөн шагнал |
| III байр – 1 | ӨРГӨМЖЛӨЛ, мөнгөн шагнал |
- Бүх оролцогчдод БАТЛАМЖ олгоно.

Сургалт арга зүйн зөвлөл